

ҮНДЭСНИЙ ХӨГЖМИЙН ИХ НАЙРАЛД ЗОРИУЛСАН УДИРТГАЛ ХӨГЖМИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

2024 оны 09 сарын 09 өдөр

Улаанбаатар хот

Тэргүүн зэргийн “ЧИНГИС ХААН” одонт, Хөдөлмөрийн баатар, Монгол улсын Төрийн шагналт, Урлагийн гавьяат зүтгэлтэн, хөгжмийн нэрт зохиолч Бямбасүрэнгийн Шаравын үндэсний хөгжмийн их найралд зориулан бичсэн "Сэрсэн тал" удиртгал хөгжим анх эгшиглэсний 40 жилийн ойд зориулав.

Уралдааны зорилго:

Үндэсний хөгжмийн их найрлын урын санг хөгжмийн “Удиртгал” төрлөөр баяжуулах, Үндэсний хөгжмийн их найралд зориулж шинэ бүтээл туурвих боломжийг нийт Монголын хөгжмийн зохиолчдод олгоход оршино.

Зохион байгуулагч: Үндэсний Урлагийн Их Театр

Хамрах хүрээ: Бүх насны хөгжмийн зохиолчид

Бүтээл хүлээн авах хугацаа ба бүртгэл:

- Оролцогчид хувийн мэдээллээ 2024 оны 11 дүгээр сарын 1-нээс 11 дүгээр сарын 15-ны 18:00 цаг хүртэл **google forms**-д бөглөнө.
- Партитура /удирдвар/, парт /хувь оноолт/-уудыг цаасан хэлбэрээр Үндэсний Урлагийн Их Театрын байр, 1-р давхар, маркетингийн албаны өрөөнд ажлын 10:00-17:00 цаг хүртэл хүлээн авна.
- Бүтээлийг дээрх хугацаанд info@grandtheatre.mn цахим шууданд **SIBELIUS хэлбэрээр илгээнэ.**

Бүтээлд тавигдах шаардлага:

1. Урьд өмнө тоглогдож байгаагүй шинэ бүтээл байна.
2. Үргэлжлэх хугацааг 3-5 минутад багтаах
3. Удиртгал хөгжим нь үндэсний хөгжмийн бүтээл байна.
4. Ёслол хүндэтгэл, баяр наадмын шинж чанар агуулсан байна.
5. Удиртгал хөгжим нь тус найрлын бүтэц, бүрэлдэхүүн, хөгжмийн зэмсгүүдийн онцлог болон диапазоныг харгалзан үзсэн байна. **/Хавсралт 1-ийн дагуу/**

Шалгаруулалтын хугацаа:

2024 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс 11 дүгээр сарын 23-ны өдрүүдийн хооронд явагдана.

Бүтээлийг шалгаруулах үе, шат:

- **I шат:** Шүүгчдийн шалгаруулалт
- **II шат:** Шүүгчдийн бүрэлдэхүүн зохих шаардлага хангаж, хоёрдугаар шатанд сонгогдсон бүтээлүүдийг найрал хөгжмийн сургуулилтад оруулна. 2024 оны 11-р сарын 23-ны өдөр 11:00 цагт Үндэсний урлагийн их театрын тайзнаа нээлттэй сонсолт явуулж шалгаруулна.

Дүгнэх зарчим:

- Шүүгчдийн бүрэлдэхүүн 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байна.
- Шүүгчид шалгаруулалт хийхдээ бүтээлд тавигдах үндсэн шаардлагыг мөрдөнө.
- Уралдаанд ирсэн бүтээлүүдийн зохиогчдын нэрсийг нууцлах ба шүүгчид шалгаруулалт хийхдээ зөвхөн бүтээлийг дүгнэн оноо тавина.
- Оролцогчдын бүтээлийг шүүгчид дүгнэхээс гадна найрал хөгжмийн хөгжимчид үнэлж эцсийн дүн гарна.

Уралдааны явцад маргаантай асуудал үүссэн тохиолдолд шүүгчид шийдвэрлэнэ. Бүх шатны шалгаруулалтад шүүгчдийн шийдвэр эцсийнх байна./

Шагнал урамшуулал:

- Нэгдүгээр байр: Батламж, 35'000'000 ₮
- Хоёрдугаар байр: Батламж, 10'000'000 ₮
- Гуравдугаар байр: Батламж, 8'000'000 ₮
- “Шарав сан”-гийн нэрэмжит шагнал.
- Үндэсний Урлагийн Их Театрын Үндэсний хөгжмийн их найрлын нэрэмжит шагнал.

Уралдааны журам:

- Уралдаанд шилдгээр шалгарсан бүтээлүүдийг Үндэсний Урлагийн Их Театр хөгжмийн зохиолчтой оюуны өмчийн хуулийн дагуу гэрээ байгуулна.
- Уралдаанд оролцсон бусад бүтээлүүдийг театрын нэмэлт гэрээгээр урын санд оруулж болно.

Шагнал гардуулах ёслол:

“СЭРСЭН ТАЛ 40” хүндэтгэлийн тоглолтын үеэр шагнал гардуулах ёслол болох бөгөөд шагналт байранд шалгарсан хөгжмийн зохиолчдын удиртгал хөгжим тус тоглолтод тоглогдоно.

Хэзээ: 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр 19:00 цагаас

Хаана: Нийслэлийн Соёлын Төв Өргөө

ҮНДЭСНИЙ УРЛАГИЙН ИХ ТЕАТРЫН ЗОХИОН

БАЙГУУЛАХ ХОРОО

Холбогдох утас: 91911591

Цахим шуудан: info@grandtheatre.mn

Хавсралт 1

Үндэсний Урлагийн Их Театрын Үндэсний Хөгжмийн Их Найрлын өнөөгийн
бүтэц бүрэлдэхүүн, дуугаралтын цар хүрээ /диапазон/

The image displays a musical score for various instruments and voices, organized into three columns. Each instrument part is represented by a staff with a clef and a key signature of one flat (B-flat). The notes are placed on the staff to indicate their pitch range. A diagonal slash on each staff indicates the range of the instrument. The instruments and their corresponding parts are:

- Column 1 (Left):**
 - жижиг лимбэ (Small Lyre)
 - Дунд лимбэ (Middle Lyre)
 - Баялаг бишгүүр (Bajlag Bishgüür)
 - Ардын бишгүүр (Arдын Bishgüür)
 - Эвэр бүрээ (Eber Büree)
 - Цордон бүдээ (Cordon Büdee)
 - Их бүрээ (Ikh Büree)
 - Их бишгүүр (Ikh Bishgüür)
- Column 2 (Middle):**
 - Ёочин (Yoochin)
 - Басс ёочин (Bass Yoochin)
 - Шанз (Shanz)
 - Ятга 21 (Yatga 21)
 - Ятга 25 (Yatga 25)
 - Басс ятга (Bass Yatga)
- Column 3 (Right):**
 - Жижиг хуучар (Small Khuchar)
 - Дунд хуучар (Middle Khuchar)
 - Морин хуур (Morin Khuur)
 - Дунд хуур (Violoncello) (Middle Khuur)
 - Их хуур (Ikh Khuur)
 - Басс хуур (Bass Khuur)

| Д/д | Хөгжмийн нэр | Диапазон | Ашигтай өнгө | Найрлын бүрэлдэхүүнд эзлэх тоо |
|------------|--|---|--|---------------------------------------|
| 1 | Жижиг лимбэ (G хөг) | 1-р октавын си бимолиос 4-р октавын ре | 1-р октавын си бимолиос 3-р октавын си бимоль | 1хүн |
| 2 | Лимбэ | Бага октавын си бимолиос 3-р октавын фа хүртэл. | Бага октавын си бимолиос 3-р октавын ре | 1хүн |
| 3 | Их лимбэ (G хөг) | Бага октавын фа-с 2-р октавын си бемоль хүртэл | Бага октавын фа-с 1-р октавын соль | 1 хүн |
| 4 | Ардын бишгүүр | Бага октавын си бимолиос 3-р октавын ми бимоль хүртэл. | Бага октавын си бимолиос 2-р октавын си бимоль | 3 хүн |
| 5 | Баялаг бишгүүр | Бага октавын си бимолиос 3-р октавын ми бимоль хүртэл. | Бага октавын си бимолиос 2-р октавын си бимоль | 2 хүн |
| 6 | Эвэр бүрээ (бичигдсэн өнгөнөөс октав доор дуугарна) | Бага октавын фа нотноос 3-р октавын ми ре хүртэл. | Бага октавын фа нотноос 3-р октавын ми | 4 хүн |
| 7 | Их бишгүүр | Контроктавын си бимолиос 1-р октавын ре хүртэл | Контроктавын си бимолиос бага октавын фа | 1 хүн |
| 8 | Цордон бүрээ (B хөг) | 1-р октавын до нотноос 3-р октавын ре хүртэл. | 1-р октавын до нотноос 2-р октавын си хүртэл | 1 хүн |
| 9 | Их бүрээ | Их октавын си бемоль нотноос 1-р октавын си бемоль хүртэл | Их октавын си бемоль нотноос 1-р октавын фа хүртэл | 1 хүн |

| | | | | |
|----|--|--|--|-------|
| 10 | Ёочин | Их октавын фа нотноос 4-р октавын ля | | |
| 11 | Басс ёочин | Контр октавын соль нотноос 1-р октавын ре | <p>Контр октавын соль, ля, си бемоль, до, ре бемоль, ре, ми бемоль, ми,фа, фа диез, соль,соль диез, ля,си бемоль,си, их октавын до, ре бемоль, ре, ми бемоль, ми,фа, фа диез, соль,соль диез, ля,си бемоль,си, Бага октавын до, ре бемоль, ре, ми бемоль, ми,фа, фа диез, соль,соль диез, ля,си бемоль, 1 октавын до, ре</p> | 4 хүн |
| 12 | Шанз (бичигдсэн өнгөнөөс октав доор дуугарна) | Бага октавын соль нотноос 4-р октавын соль хүртэл | Бага октавын соль нотноос 4-р октавын до хүртэл | 8 хүн |
| 13 | Ятга (21 утастай) | Их октавын ре нотноос 3-р октавын ре хүртэл. | | 8 хүн |
| 14 | Ятга (25 утастай) | Их октавын ми нотноос 2-р октавын ля хүртэл. | | |
| 15 | Басс ятга | Контоктавын ля бимолиос 1-р октавын ля бимоль хүртэл. | | |
| 16 | Жижиг хуучир | Бага октавын си бимолиос 2-р октавын до | Бага октавын си бимолиос 1-р октавын соль | 1 хүн |

| | | | | |
|----|---------------------------|---|--|---------|
| 17 | Дунд хуучир | 1-р октавын до нотноос 4-р октавын до хүртэл | 1-р октавын до нотноос 3-р октавын до хүртэл | 8 хүн |
| 18 | Морин хуур | Бага октавын фа нотноос 3-р октавын фа хүртэл. | Бага октавын фа нотноос 3-р октавын ре хүртэл. | 10 хүн |
| 19 | Дунд хуур (виолончель) | Их октавын до нотноос 2-р октавын ля | | 2 хүн |
| 20 | Их хуур | Контоктавын си бимолиос 1-р октавын фа хүртэл. | Контоктавын си бимолиос бага октавын фа хүртэл | 4 хүн |
| 21 | Басс их хуур | Субконтр октавын фа нотноос бага октавын ре хүртэл | | 2 хүн |
| 22 | Цохиур хөгжим | | | 4-5 хүн |